239/18/ŘED RS

-32- U TROJSKÉHO ZÁMKU 120/3 · 171 00 PRAHA 7 - TROJA · ZOO · ZOO PRAHA

# SMLOUVA O SPOLUPRÁCI

# ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

**Zoologická zahrada hl. m. Prahy, příspěvková organizace**
se sídlem: U Trojského zámku 120/3, 171 00 Praha 7 - Troja
IČO: 00064459
zastoupená Mgr. Miroslavem Bobkem, ředitelem
(dále jen „Zoo Praha")

Захирал Магистр Мирослав Бобекоор төлөөлүүлсэн Чех Улс, 171 00, Прага 7, У Тройскехо замку 120/3 тоот албан ёсны хаяг бүхий
00064459 регистрийн дугаартай,
**Нийслэл Прага хотын амьтны хүрээлэн**
(цаашид "Прагийн амьтны хүрээлэн" гэх),
нэг талаас,

a

**Great Gobi A Strictly Protected Area**
se sídlem: Box: GGSPA. PA Bayantooroi, Tsogt Soum; Gobi-Altai Aimag
Mongolsko
zastoupená Bayarbatem Choijinem, ředitelem
(dále jen „Partner")

Дарга Чойжингийн Баярбатаар төлөөлүүлсэн Монгол Улс, Говь-Алтайн аймгийн Цогт сумын Баянтоорой тосгон дахь **Говийн Их ДЦГ-ын А хэсгийн** Хамгаалалтын захиргаа
(цаашид "Түнш" гэх),
нөгөө талаас,

uzavírají tuto smlouvu o spolupráci:

харилцан тохиролцож хамтын ажиллагааны гэрээ байгуулав.

## I.
## Předmět smlouvy

## Нэгдүгээр зүйл
## Гэрээний зорилго

1. Obě smluvní strany se zavazují, že budou spolupracovat v rámci výzkumu na ochranu divokých velbloudů (*camelus ferus*) a zajistí následující:

1. Хоёр тал хавтгай (*camelus ferus*) хамгаалах судалгааны хүрээнд хамтран ажиллах үүрэг хүлээж, дараах зүйлийг хангана. Үүнд,

1.1. Zoo Praha poskytne partnerovi částku 14 400 000 MNT na nákup 8 motocyklů, typu Khairkhan 200, dle specifikace uvedené v Příloze č. 1., (dále jen „motocykly") nebo případně jiných dostupných modelů ve stejné cenové relaci, včetně pokrytí nákladů spojených s uvedením motocyklů do provozu, zajištěním potřebných povolení a převozem motocyklů z místa nákupu (Ulánbátar) do oblasti monitoringu divokých velbloudů (Gobi A) (dále jen „související náklady").

1.1. Прагийн амьтны хүрээлэн түншид хавсралт 1-д заасан техникийн тодорхойлолтын дагуу Хайрхан 200 маркийн эсвэл ижил төстэй үнийн зах зээл дээр олдож болох 8 ш мотоцикл (цаашид "мотоцикл" гэх) худалдан авах, мотоцикл ашиглалтад оруулах, шаардагдах зөвшөөрөл олгуулах, мотоцикл худалдаж авсан газар буюу Улаанбаатараас хавтгай тэмээний хяналт мониторингийн үйл ажиллагаа явуулдаг (цаашид "холбогдох зардал" гэх) газар буюу Говийн Их ДЦГ-ын А хэсэгт тээвэрлэх зорилгоор 14 400 000 төгрөг олгоно.

1.2. Partner se zavazuje realizovat nákup motocyklů dle čl. I. odst. 1.1. této

1.2. Түнш энэхүү гэрээний 1 дүгээр зүйлийн 1.1-рт заасны дагуу

[redacted]

smlouvy nejpozději do 10.6.2018. V případě, že k nákupu v uvedeném termínu nedojde, mohou se smluvní strany dohodnout na náhradním termínu. Partner se dále zavazuje zajistit oficiální předání motocyklů od zástupců Zoo Praha Partnerovi dne 23.6.2018 u příležitosti návštěvy zástupců Zoo Praha v Gobi A. Následně se partner zavazuje využívat motocykly v rámci výzkumu a terénního monitoringu populace divokých velbloudů v Mongolsku.

мотоциклийг 2018.06.10-ны өдрийн дотор худалдан авах үүрэг хүлээнэ. Мотоциклийг заасан хугацаанд худалдан авах боломжгүй болвол талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр өөр хугацаа тогтооно. Түнш мотоциклийг Прагийн амьтны хүрээлэнгийн төлөөлөгчдийг Говийн Их ДЦГ-ын А хэсэгт 2018.06.23-ны өдөр зочлох үед албан ёсоор хүлээлгэн өгөх, хүлээн авах ёслолын ажиллагааг зохион байгуулах үүрэг хүлээнэ. Цаашид мотоциклийг Монголд явуулах хавтгайн судалгаа, хээрийн хяналт мониторингийн хүрээнд ашиглах үүрэгтэй.

2. Zoo Praha zřídila sbírkové konto „Pomáháme jim přežít", na kterém jsou shromažďovány prostředky určené k ochraně ohrožených druhů živočichů a přírody. Částka uvedená v čl. I. odst. 1.1. této smlouvy bude poskytnuta z uvedeného sbírkového konta.

2. Прагийн амьтны хүрээлэн ховордсон зүйлүүдийг хамгаалахад зориулан мөнгө цуглуулж байгаа "Тэднийг устаж үгүй болохоос хамгаалж байна" хандивын дансыг нээсэн. Энэхүү гэрээний 1 дүгээр зүйлийн 1.1.-т заасан мөнгийг уг хандивын данснаас олгоно.

## II.
## Povinnosti smluvních stran

## Хоёрдугаар зүйл
## Талуудын эрх үүрэг

1. Zoo Praha poskytne Partnerovi částku uvedenou v čl. I. odst. 1.1. této smlouvy bankovním převodem. Partner není oprávněn využít finanční prostředky k jiným účelům, než které jsou uvedeny v čl. I. odst. 1.1. této smlouvy.

   Bankovní detaily Partnera:
   Jméno držitele bankovního účtu: GREAT GOBI STRICTLY PROTECTED AREA
   Název banky: KHAN BANK OF MONGOLIA
   Adresa: KHAN BANK, ULAANBAATAR, MONGOLIA
   Číslo bankovního účtu: [redacted]
   SWIFT: AGMOMNUBXXX

1. Прагийн амьтны хүрээлэн энэхүү гэрээний 1 дүгээр зүйлийн 1.1.-т заасан мөнгийг түншийн дансаар шилжүүлнэ. Түнш олгосон мөнгийг энэхүү гэрээний 1 дүгээр зүйлийн 1.1.-т заасанаас өөр зорилгоор ашиглах эрхгүй.

   Түншийн харилцах банк, дансны дугаар:
   Данс эзэмшигчийн нэр: ГОВИЙН ИХ ДАРХАН ЦААЗАТ ГАЗАР
   Банк: ХААН БАНК
   Хаяг: ХААН БАНК, УЛААНБААТАР, МОНГОЛ УЛС
   Дансны дугаар: 5335011461
   SWIFT: AGMOMNUBXXX

2. Partner zajistí veškeré administrativní záležitosti spojené s uvedením motocyklů do provozu a dodržením mongolských předpisů ohledně provozu motorových vozidel. Partner dále odpovídá za pojištění

2. Түнш мотоцикл ашиглалтад оруулж, тээврийн хэрэгсэл ашиглахтай холбоотой Монгол Улсын хууль тогтоомжид заасан бүхий л зүйлийг зохицуулна. Мөн түүнчлэн

motocyklů a za jejich následný provoz.

мотоциклийг даатгалд хамруулж, цаашид ашиглагдах нөхцлийг хариуцна.

3. Zoo Praha poskytne Partnerovi samolepky s logem, kterými budou motocykly označeny.

3. Прагийн амьтны хүрээлэнгээс түншид мотоциклд наах зорилгоор лого бүхий стикер олгоно.

4. Partner se zavazuje dodat Zoo Praha vyúčtování využitých prostředků včetně kopií daňových dokladů – faktur prokazujících uskutečnění nákupu motocyklů a souvisejících nákladů dle čl. I. odst. 1. 1. této smlouvy. Uvedené vyúčtování je partner povinen dodat nejpozději do 20.9.2018.

4. Түнш, зарцуулсан мөнгөний тооцоо, энэхүү гэрээний 1 дүгээр зүйлийн 1.1.-т зааснаар мотоцикл худалдан авч, холбогдох төлбөр хийснийг гэрчилсэн баримт (нэхэмжлэл, төлбөрийн баримт)-ын хуулбарын хамт 2018.9.20-ны өдрийн дотор Прагийн амьтны хүрээлэнд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

5. Zoo Praha je oprávněna na základě obdrženého vyúčtování požadovat od Partnera vrácení nevyčerpaných finančních prostředků. Partner se zavazuje vrátit nevyčerpanou část poskytnutých finančních prostředků nejpozději do 14 dnů po obdržení výzvy k vrácení nepoužitých finančních prostředků od Zoo Praha.

5. Прагийн амьтны хүрээлэн хүлээн авсан тооцооны үндсэн дээр зарцуулаагүй мөнгийг буцаан олгохыг шаардах эрхтэй. Түнш зарцуулаагүй мөнгийг Прагийн амьтны хүрээлэнгийн хүсэлтээр уг хүсэлт хүлээн авсан өдрөөс эхлэн 14 хоногийн дотор буцаан өгөх үүрэг хүлээнэ.

6. V případě, že k nákupu motocyklů nedojde, mohou se smluvní strany dohodnout na uzavření dohody o poskytnutí finančních prostředků k nákupu motocyklů v jiném termínu.

6. Талууд, мотоцикл энэ удаа худалдан аваагүй тохиолдолд түүнийг дараа худалдан авах зорилгоор мөнгө олгох тухай гэрээг байгуулахаар харилцан тохиролцох боломжтой.

7. Partner se zavazuje uvádět Zoo Praha jako partnera na všech informačních materiálech a v rámci veškerých svých aktivit v rámci ochrany divokých velbloudů, a to minimálně po celou dobu využívání motocyklů. Partner se dále zavazuje uvádět Zoo Praha jako partnera nebo spoluautora projektu na ochranu velbloudů divokých v rámci veškeré odborné publikační činnosti spojené s předmětem této smlouvy.

7. Түнш, мотоцикл ашиглах хугацаанаас багагүй хугацааны турш бүх мэдээлэл, танилцуулгадаа, хавтгай хамгаалах ажиллагааныхаа хүрээнд хийгдэх бүх арга хэмжээнд Прагийн амьтны хүрээлэнг өөрийн түнш болохыг дурдах үүрэг хүлээнэ. Мөн энэхүү гэрээний зорилготой холбоотой бол мэргэжлийн сэдэвт аливаа бүтээлд Прагийн амьтны хүрээлэнг хавтгай хамгаах төслийн түнш болох эсвэл төслийг хамтран санаачилсан гэдгийг заах үүрэгтэй.

## III.
## Závěrečná ustanovení

1. Smlouva nabývá platnosti dnem podpisu obou smluvních stran a účinnosti dnem zveřejnění v registru smluv. Smluvní strany souhlasí se zveřejněním této smlouvy v plném rozsahu, včetně osobních údajů ve smlouvě obsažených, jakož i všech úkonů a okolností s touto smlouvou souvisejících, či poskytnutím informace třetím osobám o této smlouvě či podstatných částech této smlouvy za podmínek definovaných zákonem č. 106/1999 Sb., o svobodném přístupu k informacím, ve znění aktuálním ke dni požadavku na informace či zveřejnění a rovněž prohlašují, že nic z obsahu této smlouvy nepovažují za obchodní tajemství. Partner bere na vědomí, že Zoo Praha je vázána zákonem č. 340/2015 Sb., o registru smluv, a souhlasí s tím, že text této smlouvy může být zveřejněn v registru smluv.

2. Smlouvu lze měnit pouze písemnými dodatky s podpisy smluvních stran na téže listině.

3. Smluvní strany nejsou oprávněny postoupit, převést, ani zastavit tuto smlouvu ani jakákoli práva, povinnosti, dluhy, pohledávky nebo nároky vyplývající z této smlouvy a v souvislosti s ní bez předchozího písemného souhlasu druhé smluvní strany. Tato smlouva je závazná rovněž pro právní nástupce smluvních stran.

4. Smlouva se vyhotovuje ve dvou vyhotoveních s platností originálu. Každá smluvní strana obdrží jeden výtisk.

## Гуравдугаар зүйл
## Бусад зүйл

1. Гэрээ нь хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Талууд Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын тухай 106/1999 тоот хуулийн дагуу мэдээлэл авах, хэвлэн нийтлүүлэх хүсэлт гаргасан өдрийн байдлаар төгөлдөр үйлчилж буй хуулийн найруулгад заасан нөхцөл хангагдсан тохиолдолд энэхүү гэрээг, гэрээнд агуулагдсан хувийн өгөгдөл, мэдээллийн хамт бүрнээр нь нийтлэх эрхтэй. Энэхүү гэрээний нөхцөл болзол, гэрээний хэрэгжилттэй холбоотой аливаа үйл ажиллагааны тухай мэдээллийг нийтлэхээс гадна мөнхүү гэрээний болон гэрээний үндсэн хэсгүүдийн талаарх мэдээллийг гуравдагч этгээдэд өгөхийг хүлээн зөвшөөрч байна. Энэхүү гэрээнд агуулагдсан зүйл нь нууцын зэрэглэлд хамаарахгүй болохыг талууд мэдэгдэж байна. Прагийн амьтны хүрээлэн нь Гэрээ хэлэлцээрийн бүртгэлийн тухай 340/2015 тоот хуулийг баримтлах үүрэгтэй болохыг түншийн зүгээс ойлгож байгаа тул уг гэрээний текстийг гэрээ хэлэлцээрийн бүртгэлд нийтлэхийг хүлээн зөвшөөрч байна.

2. Гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдсэн нэмэлт гэрээ хэлбэрээр хийх бөгөөд талууд мөн нэмэлт гэрээнд гарын үсэг зурсан байна.

3. Талууд аль нэг талын бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээ болон гэрээнээс эсвэл түүнтэй холбоотойгоор үүдэн гарах аливаа эрх, үүрэг, өр авлага, зарлага, нэхэмжлэлийг бусдад шилжүүлэх эрхгүй. Энэхүү гэрээг талуудын эрх залгамжлагчид ч дагаж мөрдөнө.

4. Энэ гэрээ хууль зүйн үүднээс ижил хүчинтэй хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг авна.

5. Tato smlouva i práva a povinnosti ve smlouvě výslovně neupravené se řídí právním řádem České republiky. Spory z této smlouvy budou řešeny obecnými soudy České republiky.

5. Энэ гэрээгээр зохицуулаагүй талуудын эрх, үүрэг Чех Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулагдах бөгөөд энэ гэрээтэй холбогдон талуудын хооронд ямарваа нэгэн маргаан үүссэн тохиолдолд түүнийг Чех Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Улаанбаатар хотноо

.......... оны .......... сарын .......... өдөр

[redacted]

**Příloha č.1. / Хавсралт 1**

# KHAIRKHAN

| MODEL | 125 | 150 | 175 | 200 |
|---|---|---|---|---|
| Volume (ml) | 124.1 | 149.4 | 175 | 197.6 |
| Fuel consumption(l/100km) | 2.1 | 2.2 | 2.3 | 2.4 |
| Related. power revolution(kw(r/min)) | 7.6/8500 | 8.0/8500 | 8.3/7500 | 9.3/7500 |
| Max torque revolution(N.m(r/min)) | 8.5/7500 | 10.8/6500 | 12.1/5500 | 14.1/5500 |
| Size(mm) | 2025×790×1050 | | | |
| Wheel Base(mm) | 1285 | | | |
| Net weight(kg) | 120 | | | |
| Max. load(kg) | 150 | | | |
| Front wheel | 2.75-18 | 3.00-18 | 3.25-18 | |
| Rear wheel | 3.00-18 | 90/90-18 | 3.25-18 | 100/90-18 |
| Max. speed | No less than 90km/h | | | |
| Brake distance | Less than 7m at 20km/h | | | |
| Climbing ability(°) | 18 | | | |
| Idle(r/min) | 1500±150 | | | |
| Spark plug | D8RC/D8EA | | | |

| | | |
|---|---|---|
| Clearance of spark plug | 0.6–0.7 | |
| Valve clearance | 0.05 | |
| Volume of oil | 1.0 | |
| Fuel tank | 11 | 15 |
| Battery | 12V,7AH | |
| Ignition | CDI | |
| Fuse | 15A | |
| Head light | 12V35W/35W | |
| Rear/brake light | 12V21W/5W | |
| Position light | 12V3W | |
| Winker | 12V10W | |
| Winker indicator | 12V3W | |
| Odometer indicator | 12V3W | |
| High beam indicator | 12V3W | |
| Gear position indicator | 12V3W | |
| Neutral light | 12V3W | |

15